

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Монгол улсын хүний гавьяат эмч Довчингомбын Товуусүрэнгийн нэрэмжит зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БНА-2026/123/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Баянхонгор хот 2026 оны 02 дүгээр сарын 25</p> <p><b>2026</b></p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат</p> <p>Утас: 70442584      Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: М.Алтантуяа</p> <p>Утас: 70442424      Цахим хаяг: <a href="mailto:altantuyam@audit.gov.mn">altantuyam@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: Б.Нарангэрэл</p> <p>Утас: 99009293      Цахим хаяг: <a href="mailto:narangerelb@audit.gov.mn">narangerelb@audit.gov.mn</a></p>
--	---

Монгол улсын хүний гавьяат эмч Довчингомбын Товуусүрэнгийн нэрэмжит Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	4
Асуудлыг онцолсон хэсэг .....	4
Аудитын гол асуудал .....	5
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	16
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.5.1 Завсрын аудитын талаар .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
5.1 Төлбөрийн акт .....	19
5.2 Албан шаардлага .....	20
5.3 Зөвлөмж .....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2026.02.16 № 2/20

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол улсын хүний гавьяат эмч Довчингомбын Товуусүрэнгийн нэрэмжит Зооноз өвчин судлалын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Зооноз өвчин судлалын төвийн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2025 онд 1,064,824.6 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1,064,824.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 1,064,744.2 мянган төгрөгийг зарцуулж, 80.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

**6426050062**

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 70 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 88.6 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  Б.МӨНХБАТ



Монгол улсын хүний гавьяат эмч Довчингомбын Товуусүрэнгийн нэрэмжит Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

**/төгрөгөөр/**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>214,286,029.36</u></b>	<b><u>173,982,491.02</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	85,421.26	00.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	85,421.26	00.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	85,421.26	00.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	85,421.26	00.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	252,720.32	5,107,090.71
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	252,720.32	4,107,090.71
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	1,000,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	213,947,887.78	168,875,400.31
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	198,844,603.59	154,355,075.70
35110	Тусгай зориулалттай материал	13,980,805.00	18,578,750.45
35130	Эм боох материал	184,863,798.59	135,776,325.25
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	15,103,284.19	14,520,324.61
35410	Бичиг хэргийн материал	2,223,600.00	1,619,200.00
35420	Аж ахуйн материал	11,962,946.67	11,856,624.00
35440	Түлш, шатах тослох материал	15,237.52	00.61
35450	Барилгын засварын материал	901,500.00	1,044,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,210,421,269.84</u></b>	<b><u>1,274,187,740.87</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,210,421,269.84	1,274,187,740.87
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,014,421,269.84	1,078,187,740.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	792,146,839.83	792,146,839.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	-111,738,758.51	-128,982,892.07
39203	Авто-тээврийн хэрэгсэл	34,150,000.00	34,150,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-17,646,666.79	-21,326,666.83
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	530,027,973.24	757,207,815.04
39206	Хуримтлагдсан элэгдэл	-224,423,908.24	-365,298,596.98
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,279,323.00	32,715,687.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,490,723.64	-24,071,064.59
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,564,917.80	14,564,917.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	-12,447,726.85	-12,918,298.33
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	196,000,000.00	196,000,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	196,869,000.00	196,869,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-869,000.00	-869,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,424,707,299.20</u></b>	<b><u>1,448,170,231.89</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>407,100.00</u></b>	<b><u>66,054,272.81</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	407,100.00	66,054,272.81
<b>413</b>	<b>Өглөг</b>	407,100.00	66,054,272.81
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	17,199,732.25
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	39,298,203.00

**Монгол улсын хүний гавьяат эмч Довчингомбын Товуусүрэнгийн нэрэмжит Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

4136	<b>Бусад өглөг</b>	407,100.00	9,556,337.56
41361	Байгууллагад төлөх өглөг	407,100.00	9,406,337.56
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	150,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,424,300,199.20</b>	<b>1,382,115,959.08</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,424,300,199.20</b>	<b>1,382,115,959.08</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	427,624,333.39	427,624,333.39
51101	Өмч: - төрийн	427,624,333.39	427,624,333.39
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>930,223,195.21</b>	<b>888,038,955.09</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	930,223,195.21	930,223,195.21
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-42,184,240.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	66,452,670.60	66,452,670.60
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,424,707,299.20</b>	<b>1,448,170,231.89</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,461,264,322.90</b>	<b>1,333,465,600.34</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>426,705,122.90</b>	<b>268,641,000.34</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>426,705,122.90</b>	<b>242,300,475.34</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	1,543,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,543,600.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		230,616,205.8
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		10,140,669.54
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>26,340,525.00</b>
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	00.00	26,340,525.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,034,559,200.00</b>	<b>1,064,824,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,034,559,200.00</b>	<b>1,064,824,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,034,559,200.00	1,064,824,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,297,042,561.38</b>	<b>1,375,649,840.46</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,297,042,561.38</b>	<b>1,375,649,840.46</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,294,259,031.95</b>	<b>1,374,321,984.46</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>777,937,584.22</b>	<b>875,913,299.97</b>
210101	Үндсэн цалин	448,583,283.80	499,642,748.67
210102	Нэмэгдэл	249,950,476.63	308,592,152.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,735,000.00	26,026,294.53
210104	Урамшуулал	58,668,823.79	41,652,104.31
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>103,183,212.91</b>	<b>114,981,000.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	66,611,659.17	71,644,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,836,665.79	8,428,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,230,850.84	13,836,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,383,758.75	4,214,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,120,278.36	16,857,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>53,106,252.49</b>	<b>87,983,702.71</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,018,753.41	6,759,614.06
210302	Түлш, халаалт	46,477,665.08	78,779,046.65
210303	Цэвэр, бохир ус	1,609,834.00	2,445,042.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>29,956,541.49</b>	<b>35,482,230.67</b>
210401	Бичиг хэрэг	5,890,850.00	6,685,250.00
210402	Тээвэр, шатахуун	10,013,976.90	11,700,218.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,820,001.50	2,397,266.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,225,000.00	1,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,006,713.09	13,699,496.67
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>129,406,666.83</b>	<b>77,034,016.34</b>

**Монгол улсын хүний гавьяат эмч Довчингомбын Товуусүрэнгийн нэрэмжит Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	117,184,399.83	77,034,016.34
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,222,267.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>24,580,900.00</b>	<b>5,280,400.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,220,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	1,200,000.00
210604	Урсгал засвар	24,580,900.00	2,860,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>15,930,400.00</b>	<b>8,500,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	15,930,400.00	8,500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,764,720.00</b>	<b>2,297,600.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	81,700.00	73,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,900.00	318,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	112,720.00	97,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	589,400.00	989,000.00
210807	Газрын төлбөр	784,000.00	782,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	11,000.00	38,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>158,392,754.01</b>	<b>166,849,734.77</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,405,940.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	155,986,814.01	166,849,734.77
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,783,529.43</b>	<b>1,327,856.00</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,783,529.43</b>	<b>1,327,856.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,783,529.43	1,327,856.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>164,221,761.52</b>	<b>-42,184,240.12</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>164,221,761.52</b>	<b>-42,184,240.12</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,034,559,200.00</b>	<b>1,092,708,725.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>27,884,125.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>00.00</b>	<b>1,543,600.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	1,543,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,543,600.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>26,340,525.00</b>
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	00.00	26,340,525.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,034,559,200.00</b>	<b>1,064,824,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,034,559,200.00</b>	<b>1,064,824,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,034,559,200.00	1,064,824,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,023,239,400.00</b>	<b>1,092,794,146.26</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,023,239,400.00</b>	<b>1,092,794,146.26</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,020,455,870.57</b>	<b>1,091,466,290.26</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>782,115,700.00</b>	<b>862,590,424.55</b>
210101	Үндсэн цалин	452,646,733.40	486,319,873.25
210102	Нэмэгдэл	250,384,017.58	308,592,152.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,540,775.09	26,026,294.53
210104	Урамшуулал	58,544,173.93	41,652,104.31
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>96,203,700.00</b>	<b>114,981,000.00</b>

**Монгол улсын хүний гавьяат эмч Довчингомбын Товуусүрэнгийн нэрэмжит Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210201	Тэтгэврийн даатгал	60,528,400.00	71,644,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,156,000.00	8,428,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,911,200.00	13,836,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,296,200.00	4,214,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,311,900.00	16,857,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>54,352,098.87</b>	<b>48,685,499.71</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,264,599.79	6,744,452.06
210302	Түлш, халаалт	46,477,665.08	39,496,005.65
210303	Цэвэр, бохир ус	1,609,834.00	2,445,042.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>23,763,351.70</b>	<b>25,380,266.00</b>
210401	Бичиг хэрэг	4,928,500.00	3,589,700.00
210402	Тээвэр, шатахуун	9,745,100.00	11,430,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,916,751.70	2,430,266.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,973,000.00	6,930,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>13,838,300.00</b>	<b>23,121,100.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,511,800.00	21,661,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,326,500.00	1,459,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>30,198,800.00</b>	<b>6,600,400.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,759,900.00	458,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	829,000.00	5,288,700.00
210604	Урсгал засвар	25,609,900.00	853,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>15,930,400.00</b>	<b>8,500,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	15,930,400.00	8,500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,573,520.00</b>	<b>1,607,600.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	81,700.00	73,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,900.00	185,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	112,720.00	97,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	791,300.00	431,900.00
210807	Газрын төлбөр	376,900.00	782,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	25,000.00	38,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,480,000.00</b>	<b>00.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,480,000.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,783,529.43</b>	<b>1,327,856.00</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,783,529.43</b>	<b>1,327,856.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,783,529.43	1,327,856.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>11,319,800.00</b>	<b>-85,421.26</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>13,799,800.00</b>	<b>00.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>13,799,800.00</b>	<b>00.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>13,799,800.00</b>	<b>00.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,799,800.00	00.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-13,799,800.00</b>	<b>00.00</b>

**Монгол улсын хүний гавьяат эмч Довчингомбын Товуусүрэнгийн нэрэмжит Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-2,480,000.00	-85,421.26
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	2,565,421.26	85,421.26
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	85,421.26	00.00

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	427,624,333.39	66,483,487.00	566,590,678.72	1,060,698,499.11
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>427,624,333.39</b>	<b>66,483,487.00</b>	<b>566,590,678.72</b>	<b>1,060,698,499.11</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-28,404,979.71	-28,404,979.71
C08	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>427,624,333.39</b>	<b>66,452,670.60</b>	<b>930,223,195.21</b>	<b>1,424,300,199.20</b>
D01	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>427,624,333.39</b>	<b>66,452,670.60</b>	<b>930,223,195.21</b>	<b>1,424,300,199.20</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>427,624,333.39</b>	<b>66,452,670.60</b>	<b>930,223,195.21</b>	<b>1,424,300,199.20</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-42,184,240.12	-42,184,240.12
D09	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>427,624,333.39</b>	<b>66,452,670.60</b>	<b>888,038,955.09</b>	<b>1,382,115,959.08</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Тайлант оны			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,064,824,600.00	1,064,824,600.00	0.0	100.00
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,064,824,600.00	1,064,824,600.00	0.0	100.00
Улсын төсвөөс санхүүжих	1,064,824,600.00	1,064,824,600.00	0.0	100.00
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,064,824,600.00	1,064,744,165.26	80,434.7	99.99
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,064,824,600.00	1,064,744,165.26	80,434.7	99.99
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,064,824,600.00	1,064,744,165.26	80,434.7	99.99
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	837,249,900.00	837,249,899.55	0.5	100.00
Үндсэн цалин	452,181,100.00	486,319,873.25	34,138,773.3	107.55
Нэмэгдэл	290,418,100.00	283,251,627.46	7,166,472.5	97.53
Унаа хоолны хөнгөлөлт	38,558,000.00	26,026,294.53	12,531,705.5	67.50

**Монгол улсын хүний гавьяат эмч Довчингомбын Товуусүрэнгийн нэрэмжит Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Урамшуулал	56,092,700.00	41,652,104.31	14,440,595.7	74.26
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	114,981,000.00	114,981,000.00	0.0	100.00
Тэтгэврийн даатгал	71,644,200.00	71,644,200.00	0.0	100.00
Тэтгэмжийн даатгал	8,428,800.00	8,428,800.00	0.0	100.00
ҮОМШӨ-ний даатгал	13,836,200.00	13,836,200.00	0.0	100.00
Ажилгүйдлийн даатгал	4,214,300.00	4,214,300.00	0.0	100.00
Эрүүл мэндийн даатгал	16,857,500.00	16,857,500.00	0.0	100.00
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	48,685,500.00	48,685,499.71	0.3	100.00
Гэрэл, цахилгаан	5,399,100.00	6,744,452.06	-1,345,352.1	124.92
Түлш, халаалт	40,372,300.00	39,496,005.65	876,294.4	97.83
Цэвэр, бохир ус	2,914,100.00	2,445,042.00	469,058.0	83.90
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	24,381,200.00	24,380,266.00	934.0	100.00
Бичиг хэрэг	2,276,400.00	2,589,700.00	-313,300.0	113.76
Тээвэр, шатахуун	14,100,400.00	11,430,000.00	2,670,400.0	81.06
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,442,000.00	2,430,266.00	11,734.0	99.52
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	986,300.00	1,000,000.00	-13,700.0	101.39
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,576,100.00	6,930,300.00	-2,354,200.0	151.45
<b>Нормативт зардал</b>	22,739,500.00	22,739,500.00	0.0	100.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,279,800.00	21,279,800.00	0.0	100.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,459,700.00	1,459,700.00	0.0	100.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,624,100.00	6,600,400.00	23,700.0	99.64
Багаж, техник, хэрэгсэл	458,300.00	458,300.00	0.0	100.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,312,400.00	5,288,700.00	23,700.0	99.55
Урсгал засвар	853,400.00	853,400.00	0.0	100.00
<b>Томилолт, зочны зардал</b>	8,500,000.00	8,500,000.00	0.0	100.00
Дотоод албан томилолт	8,500,000.00	8,500,000.00	0.0	100.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,663,400.00	1,607,600.00	55,800.0	96.65
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	73,200.00	-73,200.0	
Даатгалын үйлчилгээ	185,100.00	185,100.00	0.0	100.00
Тээврийн хэрэгслийн татвар	102,500.00	97,000.00	5,500.0	94.63
Тээврийн хэрэгслийн оношилгоо	23,700.00	00.00	23,700.0	0.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	515,900.00	431,900.00	84,000.0	83.72
Газрын төлбөр	782,400.00	782,400.00	0.0	100.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	53,800.00	38,000.00	15,800.0	70.63
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,064,824,600.00	1,064,824,600.00	0.0	100.00
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,064,824,600.00	1,064,824,600.00	0.0	100.00
Улсын төсвөөс санхүүжих	1,064,824,600.00	1,064,824,600.00	0.0	100.00
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	28	25		
Удирдах ажилтан	01	01		
Гүйцэтгэх ажилтан	28	25		
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	29	26		

**Монгол улсын хүний гавьяат эмч Довчингомбын Товуусүрэнгийн нэрэмжит Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	19	21		
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10	05		

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	26,722,125.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	26,722,125.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	26,722,125.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	25,340,525.00
210102	Нэмэгдэл	25,340,525.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,000,000.00
210401	Бичиг хэрэг	1,000,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	381,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	381,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,000,000.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	1,000,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	26,722,125.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	26,722,125.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,340,525.00
	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,381,600.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

**3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Монгол улсын хүний гавьяат эмч Довчингомбын нэрэмжит Зоонозын өвчин судлалын төв нь “Ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах жил,Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах” гэсэн зорилгын дор үйл ажиллагаагаа явуулж байна.

**3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд Зооноз өвчин судлалын үндэсний төвийн дотоод аудитын газраас тус байгууллагад хяналт, шалгалт хийгээгүй байна.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Монгол улсын хүний гавьяат эмч Довчингомбын Товуусүрэнгийн нэрэмжит Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол улсын хүний гавьяат эмч Довчингомбын нэрэмжит Зоонозын өвчин судлалын төв нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Монгол улсын хүний гавьяат эмч Довчингомбын нэрэмжит Зоонозын өвчин судлалын төв нь Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс эрхлэн гаргасан “Эрүүл мэндийн салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа нь стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Монгол улсын хүний гавьяат эмч Довчингомбын Товуусүрэнгийн нэрэмжит Зоонозын өвчин судлалын төв нь 2025 оны санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23,462.9 мянган төгрөг буюу 1.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өөрчлөлт	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
	1	2	3	4	5	6
<b>А</b>						
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	214,286.0	15.0%	173,982.5	12.0%	(40,303.5)	-18.8%
Мөнгөн хөрөнгө	85.4	0.0%	-	0.0%	(85.4)	-100.0%
Авлага	252.7	0.0%	5,107.1	0.4%	4,854.4	1920.8%
Урьдчилгаа	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Бараа материал	213,947.9	15.0%	168,875.4	11.7%	(45,072.5)	-21.1%
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,210,421.3	85.0%	1,274,187.7	88.0%	63,766.5	5.3%
Үндсэн хөрөнгө	1,597,038.1	112.1%	1,827,654.3	126.2%	230,616.2	14.4%
Хуримтлагдсан элэгдэл	(386,616.8)	-27.1%	(553,466.5)	-38.2%	(166,849.7)	43.2%
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,424,707.3</b>	<b>100.0%</b>	<b>1,448,170.2</b>	<b>100.0%</b>	<b>23,462.9</b>	<b>1.6%</b>
Өр төлбөр	407.1	0.0%	66,054.3	4.6%	65,647.2	16125.6%
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,424,300.2	100.0%	1,382,116.0	95.4%	(42,184.2)	-3.0%
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,424,707.3</b>	<b>100.0%</b>	<b>1,448,170.2</b>	<b>100.0%</b>	<b>23,462.9</b>	<b>1.6%</b>

Эх сурвалж: Байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан

Авлага дансны үлдэгдэл 5,107.1 мянган төгрөг болж 4,854.4 мянган төгрөгөөр өссөн нь ажилчдад олгосон урьдчилгаа цалинг буцаан суутгаагүй авлагаар тусгасантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 168,875.4 мянган төгрөг болж 45,072.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Төсвийн худалдан авалтаар 57,988.2 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 7,272.1 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, 1,763.5 мянган

төгрөгийн тусгай зориулалтын материал, 1,105.0 мянган төгрөгийн хангамжийн материал, шатахууныг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан бөгөөд нийт 110,310.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 5,890.6 мянган төгрөгийн бараа материал акталж устгасан нь бараа материалын данс буурахад голлох нөлөө үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,827,654.3 мянган төгрөг болж 230,616.2 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 5/05 дугаар тогтоолоор 219,132.0 мянган төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж, Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/171 дүгээр тушаалаар 2897.8 мянган төгрөгийн өртөг бүхий лабораторийн хөргөгч, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагаас 3786.4 мянган төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж, Зооноз өвчин судлалын үндэсний төвөөс 4,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий зөөврийн интернэтийг шилжүүлэн авч, иргэн аж ахуйн нэгж байгууллагын хандиваар 800.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 66,054.3 мянга болж 65,647.2 мянган төгрөгөөр өссөн нь 2025 оны 07 дугаар сард 3 орон тоог бууруулж баталсантай холбоотойгоор ХХОАТ-ын өглөг 15,956.9 мянга, мөн 2024 онд халаалтын зардлыг 82,925.0 мянган төгрөгөөр төсөвлөн төсвийн төслийг хүргүүлж байсан ч 40,732.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж 39,283.0 мянган төгрөгийн халаалтын зардлын өглөг үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,382,116.0 мянган төгрөг болж 42,184.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 42,184.2 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Тайлант онд тус байгууллага нь Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ны 869.0 мянган төгрөгийн өртөг бүхий Acolous accounting system 4.0 санхүүгийн программ хангамжийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд тайлант онд лицензийн төлбөрт 323.6 мянган төгрөгийн төлбөр төлсөн байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,856,729.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,856,729.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 791,904.4 мянган төгрөгөөр бууруулж 1,064,824.6 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 1,120,337.6 мянган төгрөгийн төсөв баталсан ч 2025 оны сүүлчээр төсвийг тодотгон 1,064,824.6 мянган төгрөгөөр баталсан бөгөөд улсын төсвийн санхүүжилтээр 1,064,824.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,064,744.2 мянган төгрөгийг зарцуулж, 80.4 мянган төгрөгийн улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,064,744.2 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь эд хогшил, урсгал завсрын зардал 23.7 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 55.8 мянган төгрөгийг зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт %
1	71601 Нийгмийн эрүүл мэнд	1,064,824,600.00	1,064,744,165.20	80,434.80	99.9
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,064,824,600.00	1,064,744,165.20	80,434.80	99.9
2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	0.00	0.00	0.00	

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үр дүнг нэгтгэв.

1. Бүтэц орон тоог Монгол улсын хүний гавьяат эмч Довчингомбын Товуусүрэнгийн нэрэмжит Зоонозын өвчин судлалын төвийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар удирдах 1, гүйцэтгэх 18, үйлчлэх 10, нийт 29 албан хаагчийн орон тоог баталсан бөгөөд 2025 оны 11 дүгээр сард 2 гүйцэтгэх албан тушаалтан тэтгэвэрт гарч орон тоог нь царцааж, 1 гүйцэтгэх албан хаагчийн орон тоог цомхотгон, гүйцэтгэлээр 26 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

2. Тус байгууллагын төсөвт хоолны хөнгөлөлтийг 38,558.0 мянган төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр 26,026.3 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд Засгийн газрын Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8.4 дэх заалтыг үндэслэн өдрийн 5.0 мянган төгрөгөөр тооцон олгосон байна.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд тус байгууллагад төсөл хөтөлбөр хэрэгжээгүй болно.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Петровис ХХК-тай шууд гэрээ байгуулан 11,684.9 мянган төгрөгийн шатахуун худалдан авсан байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 26,340.5 мянга, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 1,381.6 мянган төгрөгийн орлогыг Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд 25,340.5 мянга, эм эмнэлгийн хэрэгсэл, хангамжийн зардалд 1,381.6 мянган төгрөгийн зарцуулж, орон нутгийн төсөвт 1,000.0 мянган төгрөгийн буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монгол улсын хүний гавьяат эмч Довчингомбын Товуусүрэнгийн нэрэмжит Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Монгол улсын хүний гавьяат эмч Довчингомбын Товуусүрэнгийн нэрэмжит Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2025 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын дарга Б.Алтанчимэг, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Т.Одонтуяа нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн

гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны нийт батлагдсан төсөвт зардал 1,064,824.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 15,972.4 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 11,180.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2025 оны байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болон бичиг хэргийн зардалд хэмнэлт бий болоогүй байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2025 онд 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 166 мэдээллийг бүрэн байршуулсан бөгөөд 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 254,052.0 мянган төгрөгийн 3 гүйлгээ, хуулийн 6.1.5-д заасан санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, 6.1.2-д заасан төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэлийг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.5, 6.4.5-д заасан мэдээллийг хугацаанд бүрэн байршуулж, түүнд хяналт тавьж байх зөвлөмжийг аймгийн Эрүүл мэндийн газрын тайланд тусгахаар шийдвэрлэв.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Дорж гүйцэтгэж, аудитаар илэрсэн зөрчилд 121,573.7 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2025.05.14-ний өдрийн 84 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт					
Албан шаардлага	3	121,573.7	3	121,573.7	100
Зөвлөмж					
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>121,573.7</b>	<b>3</b>	<b>121,573.7</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд байгууллагын даргын А/01 дүгээр тушаалаар нийт 29 албан хаагчийн орон тоог баталсан бөгөөд 2025 оны 07 дугаар сард бүтэц орон тоог 26 албан хаагч байхаар төсвийг баталсан бөгөөд 11 дүгээр сар хүртэл 29 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байгаад 2 албан хаагч өндөр насны тэтгэвэртээ гарснаас шалтгаан тус байгууллагад ХХОАТ-ын өглөг 15,956.9 мянган төгрөгийн өглөг үүссэн.

2024 онд халаалтын зардлыг 82,925.0 мянган төгрөгөөр төсөвлөн төсвийн төслийг хүргүүлж байсан ч 40,732.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж 39,283.0 мянган төгрөгийн өглөг үүссэн байна. Энэхүү өр төлбөрийг барагдуулах хүсэлтийг Эрүүл мэндийн яам болон аймгийн Эрүүл мэндийг газарт удаа дараа албан бичгээр хүргүүлж байсан ч шийдвэрлэгдээгүй байна. Иймд дээрх өр төлбөрүүдийг барагдуулсан эсэхийг дараагийн аудитаар анхаарч үзэх зайлшгүй шаардлагатай байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 254,052.0 мянган төгрөгийн 3 гүйлгээ, хуулийн 6.1.5-д заасан санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, 6.1.2-д заасан төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэлийг хугацаа хоцорч мэдээлсэн байгаа тул дараагийн аудитаар шилэн дансны цахим хуудаст хугацаандаа бүрэн мэдээлсэн эсэхийг анхаарч үзэх шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 234,963.6 мянган төгрөгийн 3 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад цалингаас суутгасан 1,242.8 мянган төгрөгийн үйлдвэрчний эвлэлийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байгаа нь УСНББОУС-1 Толилуулга ба тодруулга, УСНББОУС-30 Санхүүгийн хэрэглүүр, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх, мөн иж бүрэн байх, Оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

2. Тайлант онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хүлээн авсан 226,029.8 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар хүлээн авсан гэсэн ангиллаар бүртгэсэн байгаа нь УСНББОУС-1 Толилуулга ба тодруулга, УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, мөн ангилал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3. Тайлант хугацааны нярвын тайлан нь санхүүгийн тайлангаас орлого 24.9 мянган төгрөгөөр дутуу, зарлага 7,716.0 мянган төгрөгөөр дутуу нийт 7,691.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байгаа нь УСНББОУС-1 Толилуулга ба тодруулга, УСНББОУС-12 Бараа материал, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх, мөн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 306,336.1 мянган төгрөгийн 5 зөрчил<sup>2</sup> илэрснээс 6,769.6 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 14,225.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 285,341.5 мянган төгрөгийн 2 заалт бүхий зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс материаллаг алдаа зөрчил буюу 6,769.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 9,202.8 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Байгууллагын санхүүгийн ажилтнуудад нийт 2,664.0 мянган төгрөгийн балансын урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон урамшуулал болох 2,664.0 мянган төгрөгийг холбогдох албан тушаалтнуудаар буцаан төлүүлэх төлбөрийн актыг тогтоож, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1.2 Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад ажилтнуудад 12 сард олгосон 4,105.6 мянган төгрөгийн урьдчилгааг суутган тооцоогүй авлагаар тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилчдаас суутгаагүй цалингийн урьдчилгаа болох 4,105.6 мянган төгрөгийг суутган тооцож, орон нутгийн орлогод төвлөрүүлэх төлбөрийн актыг тогтоож, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

## 5.2 Албан шаардлага

5.2.1 Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад 9 ажилтны 14,225.0 мянган төгрөгийн цалинг нийгмийн даатгалын санд илүү мэдээлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “Үнэн зөв байх”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө”, 32 дугаар зүйлийн 32.2.2 “Орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын санд илүү мэдээлсэн 14,225.0 мянган төгрөгийн зөрүүг тооцож, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

## 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацааны урсгал зардлыг тулгахад 15.2 мянган төгрөгийн цахилгааны өглөг, бусад байгууллагад өгөх 9,321.7 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид дээрх өглөгийг барагдуулж Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

### 2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд 276,004.6 мянган төгрөгийн анхны өртөг бүхий элэгдлээрээ өртгөө нөхсөн 73 нэр төрлийн 263 хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгссөн зөвлөмж: Цаашид элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглалтыг шаардлага хангасан хөрөнгийг дахин үнэлэх, ашиглалтын шаардлага хангаагүй хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр данс бүртгэлээс хасах арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Алдааны товч утга	Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл						/мянган төгрөгөөр/			
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад 1,242.8 мянган төгрөгийн үйлдвэрчний эвлэлийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.	1	1,242.8	1	1,242.8			1	1,242.8		
Тайлант онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хүлээн авсан 226,029.8 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар хүлээн авсан гэсэн ангиллаар бүртгэсэн	1	226,029.8			1	226,029.8	1	226,029.8		
Тайлант хугацааны нярвын тайлан нь санхүүгийн тайлангаас орлого 24.9 мянган төгрөгөөр дутуу зарлага 7,716.0 мянган төгрөгөөр дутуу нийт 7,691.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн	1	7,691.0	1	7,691.0			1	7,691.0		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>234,963.6</b>	<b>2</b>	<b>8,933.8</b>	<b>1</b>	<b>226,029.8</b>	<b>3</b>	<b>234,963.6</b>		

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын санхүүгийн ажилтнуудад нийт 2,664.0 мянган төгрөгийн балансын урамшууллыг давхардуулан олгосон байна.	1	2,664.0	1	2,664.0				
Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад ажилтнуудад 12 сард олгосон 4,105.6 мянган төгрөгийн урьдчилгааг суутган тооцоогүй авлагаар тусгасан байна.	1	4,105.6	1	4,105.6				
Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад 9 ажилтны 14,225.0 мянган төгрөгийн цалинг нийгмийн даатгалын санд илүү мэдээлсэн байна.	1	14,225.0			1	14,225.0		
Тайлант хугацааны урсгал зардлыг тулгахад 15.2 мянган төгрөгийн цахилгааны өглөг, бусад байгууллагад өгөх 9,321.7 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна.	1	9,336.9					1	9,336.9
Байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд 276,004.6 мянган төгрөгийн анхны өртөг бүхий элэгдлээрээ өртгөө нөхсөн 73 нэр төрлийн 263 хөрөнгө бүртгэлтэй байна.	1	276,004.6					1	276,004.6
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>306,336.1</b>	<b>2</b>	<b>6,769.6</b>	<b>1</b>	<b>14,225.0</b>	<b>2</b>	<b>285,341.5</b>

-----oOo-----





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 15/А0560241/БНА-2026/123/НА-Номгон  
-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол улсын хүний гавьяат эмч Довчингомбын Товуусүрэнгийн нэрэмжит зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын санхүүгийн ажилтнуудад нийт 2,664,000 /хоёр сая зургаан зуун жаран дөрвөн мянга/ төгрөгийн балансын урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон урамшуулал 2,664,000 /хоёр сая зургаан зуун жаран дөрвөн мянган/ төгрөгийг холбогдох албан тушаалтнуудаар буцаан төлүүлж Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2026 оны 05 дугаар сарын 10-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Монгол улсын хүний гавьяат эмч Довчингомбын Товуусүрэнгийн нэрэмжит зоонозын өвчин судлалын төвийн дарга Б.Алтанчимэг, нягтлан бодогч Т.Одонтуяа нарт хариуцуулав<sup>1</sup>.

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН<sup>2</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР **Б.МӨНХБАТ**

АХЛАХ АУДИТОР

**Б.НАРАНГЭРЭЛ**



<sup>1</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>2</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 16/A0560241/Б11А-2026/123/НА-ГА-ТМЗ Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол улсын хүний гавьяат эмч Довчингомбын Товуусүрэнгийн нэрэмжит Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад ажилтнуудад 12 сард олгосон 4,105,600 /дөрвөн сая нэг зуун таван мянга зургаан зуун/ төгрөгийн цалингийн урьдчилгааг суутган тооцоогүй авлагаар тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.


Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ажилчдаас суутгаагүй цалингийн урьдчилгаа болох 4,105,600 /дөрвөн сая нэг зуун таван мянга зургаан зуун/ төгрөгийг холбогдох ажилтнуудаас суутган тооцож, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

0426110046

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2026 оны 05 дугаар сарын 10-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Монгол улсын хүний гавьяат эмч Довчингомбын Товуусүрэнгийн нэрэмжит зоонозын өвчин судлалын төвийн дарга Б.Алтанчимэг, нягтлан бодогч Т.Одонтуяа нарт хариуцуулав<sup>1</sup>.

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН<sup>2</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР

 Б.НАРАНГЭРЭЛ



<sup>1</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>2</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 57/АДББ0241/БНА-2026/123/  
НА-СТА-ТШЗ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол улсын хүний гавьяат эмч Довчингомбын Товуусүрэнгийн нэрэмжит Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад хавсралтад буй нэр бүхий 9 ажилтны 14,225,000 /Арван дөрвөн сая хоёр зуун хорин таван мянган/ төгрөгийн цалинг нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээнд илүү мэдээлсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “Үнэн зөв байх”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө”, 32 дугаар зүйлийн 32.2.2 “Орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

6426090184

/documents/2026 он/1. бичиг  
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

1. Нийгмийн даатгалын санд илүү мэдээлсэн 14,225,000 /Арван дөрвөн сая хоёр зуун хорин таван мянган/ төгрөгийн зөрүүг тооцож, зөрчлийг арилган, биелэлтийг нотлох баримтын хамт 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол улсын хүний гавьяат эмч Довчингомбын Товуусүрэнгийн нэрэмжит зоонозын өвчин судлалын төвийн дарга Б.Алтанчимэг, нягтлан бодогч Т.Одонтуяа нарт даалгав<sup>1</sup>.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>2</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

Б.НАРАНГЭРЭЛ



<sup>1</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>2</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно